**ХОВД  АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн  2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/031/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд  хот<br>2026 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор:  Х.Болдбаатар<br>Утас: 70433061   Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545   Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК -ын  Аудитор: Д.Балжинням<br>Утас:70432545   Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....................6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....................10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....................11
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................13
3.1. Төлбөрийн акт....................14
3.2 Албан шаардлага....................14
3.3 Зөвлөмж....................14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................16
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл....................18

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

171

ХОВД АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
-84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.24 № 133

танай ______ -ны № ______ -т

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Б.ТҮМЭНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Онцлох асуудал нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 224.9 сая төгрөг, үүний 47.3 сая төгрөг нь он дамжсан үлдэгдэл байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал төсвөөс 45.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон хандив тусламжаар 385.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

8426050285

172

**Бусад асуудал**

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 хөтөлбөр, 12 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 96.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,184,462,463.74** | **1,035,262,027.92** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,202,373.74 | 361,100,574.71 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,202,373.74 | 361,100,574.71 |
| **3121** | **Төгрөг** | 2,202,373.74 | 361,100,574.71 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 2,202,373.74 | 361,100,574.71 |
| **33** | **АВЛАГА** | 707,593,753.15 | 267,447,982.07 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 4,937,424.62 | 4,348,154.64 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.50 | 0.50 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 697,814,529.90 | 258,258,028.80 |
| **335** | **Бусад авлага** | 4,841,798.13 | 4,841,798.13 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 879,603.13 | 879,603.13 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3,962,195.00 | 3,962,195.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 474,598,336.85 | 406,645,471.14 |
| **351** | **Түүхий эд материал** | 307,503,715.01 | 243,342,349.30 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 34,017,611.50 | 19,690,609.50 |
| 35130 | Эм боох материал | 273,486,103.51 | 223,651,739.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 165,054,621.84 | 161,263,121.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,091,000.00 | 1,091,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,460,700.00 | 14,460,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 120,024,458.20 | 120,024,458.20 |
| 35460 | Хүнсний материал | 16,132,240.00 | 16,132,240.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,346,223.64 | 9,554,723.64 |
| 35600 | Мал амьтад | 2,040,000.00 | 2,040,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 68,000.00 | 68,000.00 |
| 36400 | Шатахууны нөөц | 68,000.00 | 68,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,610,852,708.81** | **7,680,346,018.49** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,610,852,708.81 | 7,680,346,018.49 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,597,348,708.81 | 7,666,842,018.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,236,933,339.00 | 7,236,933,339.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,050,890,689.00) | (1,225,757,425.00) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 335,837,494.50 | 511,009,894.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (168,516,371.45) | (193,823,361.53) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,165,690,979.75 | 1,855,932,007.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (965,179,735.76) | (589,865,003.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,281,360.00 | 71,129,856.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,807,668.15) | (12,717,288.91) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,000,000.08) | (6,000,000.12) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,504,000.00 | 13,504,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,525,000.00 | 1,525,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,525,000.00) | (1,525,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,504,000.00 | 13,504,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,795,315,172.55** | **8,715,608,046.41** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **34,135,089.86** | **16,612,316.27** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 34,135,089.86 | 16,612,316.27 |
| **413** | **Өглөг** | 34,135,089.86 | 16,612,316.27 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 27,353,405.26 | 16,021,376.19 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,657,969.84 | 590,940.08 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,761,180,082.69** | **8,698,995,730.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 8,761,180,082.69 | 8,698,995,730.14 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 470,965,819.00 | 470,965,819.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 470,965,819.00 | 470,965,819.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,111,519,465.32 | 8,084,949,332.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8,111,519,465.32 | 8,147,133,684.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (62,184,352.55) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 178,694,798.37 | 143,080,578.87 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,795,315,172.55** | **8,715,608,046.41** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,740,159,509.46** | **4,938,210,792.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **634,736,527.46** | **755,625,665.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 634,736,527.46 | 334,220,616.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 634,736,527.46 | 755,625,665.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,095,300.00 | 61,992,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 272,288,416.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 536,437,772.70 | 385,102,704.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 38,203,454.76 | 36,242,345.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,105,422,982.00** | **4,182,585,127.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 291,634,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 291,634,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,825,165,382.00 | 3,890,950,927.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,825,165,382.00 | 3,890,950,927.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,946,688,946.59** | **5,000,395,144.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,946,688,946.59** | **5,000,395,144.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,939,409,346.59 | 4,753,254,136.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,262,877,498.53 | 2,773,928,594.73 |
| 210101 | Үндсэн цалин | 1,087,131,813.94 | 1,350,259,279.45 |
| 210102 | Нэмэгдэл | 865,652,332.98 | 1,051,948,025.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 86,450,000.00 | 174,520,000.00 |
| 210104 | Урамшуулал | 200,378,451.15 | 197,201,290.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 290,424,904.23 | 353,386,297.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 192,552,404.23 | 241,399,433.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,468,100.00 | 27,604,813.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,234,100.00 | 17,394,794.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,234,100.00 | 13,397,451.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 48,936,200.00 | 53,589,805.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 274,706,000.00 | 284,225,140.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,984,539.96 | 29,981,268.08 |
| 210302 | Түлш, халаалт | 236,504,820.04 | 240,566,272.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,216,640.00 | 13,677,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 123,673,484.00 | 167,168,377.17 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,007,700.00 | 18,083,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 71,725,909.00 | 75,593,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,108,675.00 | 6,484,553.17 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 22,000.00 | 2,090,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,123,000.00 | 2,600,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 30,686,200.00 | 62,317,264.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 580,657,917.21 | 728,243,916.06 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 525,750,017.21 | 648,879,566.06 |
| 210502 | Хоол, хүнс | 51,117,900.00 | 76,877,850.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,790,000.00 | 2,486,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,624,640.00 | 37,106,750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,269,640.00 | 10,365,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,275,000.00 | 26,741,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,801,400.00 | 6,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,801,400.00 | 6,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,122,910.00 | 29,866,116.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,541,750.00 | 21,438,116.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,997,000.00 | 5,978,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,000,000.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 372,520,592.62 | 372,458,944.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,154,365.00 | 11,405,050.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 361,366,227.62 | 361,053,894.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,279,600.00 | 247,141,008.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 247,141,008.40 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 62,347,008.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 184,794,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **793,470,562.87** | **(62,184,352.55)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **793,470,562.87** | **(62,184,352.55)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,744,798,552.10** | **4,956,422,244.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,095,300.00** | **334,280,616.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 60,095,300.00 | 334,280,616.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 60,095,300.00 | 334,280,616.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,095,300.00 | 61,992,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 272,288,416.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,684,703,252.10** | **4,622,141,628.10** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 280,257,600.00 | - |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 280,257,600.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 291,634,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 291,634,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,404,445,652.10 | 4,330,507,428.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,404,445,652.10 | 4,330,507,428.10 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,696,894,157.75** | **4,597,524,043.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,696,894,157.75** | **4,597,524,043.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,689,614,557.75** | **4,333,415,034.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,258,715,526.85 | 2,750,499,247.41 |
| 210101 | Үндсэн цалин | 1,097,780,783.68 | 1,289,136,629.06 |
| 210102 | Нэмэгдэл | 865,652,332.98 | 1,110,992,403.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 86,450,000.00 | 172,700,000.00 |
| 210104 | Урамшуулал | 185,294,864.15 | 177,670,214.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 308,148,900.00 | 370,405,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 210,276,400.00 | 249,731,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,468,100.00 | 30,168,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,234,100.00 | 15,084,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,234,100.00 | 15,084,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 48,936,200.00 | 60,337,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 272,978,000.00 | 283,634,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,984,539.96 | 29,390,328.00 |
| 210302 | Түлш, халаалт | 234,776,820.04 | 240,566,272.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,216,640.00 | 13,677,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 100,900,984.00 | 130,216,473.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,600,400.00 | 16,470,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 62,296,209.00 | 75,593,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,108,675.00 | 11,256,563.93 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 22,000.00 | 2,090,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,873,700.00 | 24,805,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 673,699,388.00 | 659,102,429.39 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 618,392,671.90 | 582,578,529.39 |
| 210502 | Хоол, хүнс | 47,828,050.00 | 64,532,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,478,666.10 | 11,991,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,788,898.90 | 85,278,364.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,828,898.90 | 50,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,880,000.00 | 35,278,364.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,801,400.00 | 6,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,801,400.00 | 6,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,581,160.00 | 26,083,820.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,000,000.00 | 15,750,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,227,400.00 | 867,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 202,760.00 | 711,220.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 326,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,997,000.00 | 5,978,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,000,000.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,000,300.00 | 21,324,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,000,300.00 | 21,324,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,279,600.00** | **264,109,008.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 264,109,008.40 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 62,347,008.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 201,762,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **47,904,394.35** | **358,898,200.97** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,259,500.00** | **45,444,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,259,500.00** | **45,444,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,259,500.00 | 45,444,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,259,500.00 | 45,444,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(49,259,500.00)** | **(45,444,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,355,105.65) | 313,453,700.97 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 2,202,373.74 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,202,373.74 | 361,100,574.71 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 470,965,819.00 | 178,694,798.37 | 8,111,519,465.32 | 8,761,180,082.69 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 35,614,219.50 | 35,614,219.50 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **470,965,819.00** | **178,694,798.37** | **8,147,133,684.82** | 8,796,794,302.19 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (35,614,219.50) | - | (35,614,219.50) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **470,965,819.00** | **143,080,578.87** | **8,147,133,684.82** | 8,761,180,082.69 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **470,965,819.00** | **143,080,578.87** | **8,147,133,684.82** | 8,761,180,082.69 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 35,614,219.50 | 35,614,219.50 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **470,965,819.00** | **143,080,578.87** | **8,182,747,904.32** | 8,796,794,302.19 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (35,614,219.50) | - | (35,614,219.50) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (62,184,352.55) | (62,184,352.55) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **470,965,819.00** | **107,466,359.37** | **8,120,563,551.77** | 8,698,995,730.14 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(Төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,941,561,400.00 | 4,597,524,043.13 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,941,561,400.00 | 4,597,524,043.13 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,669,321,000.00 | 4,333,415,034.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,963,247,600.00 | 2,750,499,247.41 |
| 210101 | Үндсэн цалин | 1,344,735,400.00 | 1,289,136,629.06 |
| 210102 | Нэмэгдэл | 1,223,568,900.00 | 1,110,992,403.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 151,404,800.00 | 172,700,000.00 |
| 210104 | Урамшуулал | 243,538,500.00 | 177,670,214.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 370,405,900.00 | 370,405,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 249,731,900.00 | 249,731,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 30,168,500.00 | 30,168,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,084,200.00 | 15,084,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,084,200.00 | 15,084,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 60,337,100.00 | 60,337,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 283,634,200.00 | 283,634,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,390,328.00 | 29,390,328.00 |
| 210302 | Түлш, халаалт | 240,566,272.00 | 240,566,272.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,677,600.00 | 13,677,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 154,240,400.00 | 130,216,473.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,496,000.00 | 16,470,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 90,003,300.00 | 75,593,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,015,700.00 | 11,256,563.93 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,725,400.00 | 2,090,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,000,000.00 | 24,805,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 756,218,900.00 | 659,102,429.39 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 672,618,900.00 | 582,578,529.39 |
| 210502 | Хоол, хүнс | 71,600,000.00 | 64,532,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,000,000.00 | 11,991,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 85,307,900.00 | 85,278,364.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,307,900.00 | 35,278,364.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,257,000.00 | 6,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,257,000.00 | 6,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,684,100.00 | 26,083,820.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,000,000.00 | 15,750,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,440,000.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,247,400.00 | 867,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 712,800.00 | 711,220.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,086,900.00 | 326,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,978,000.00 | 5,978,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 120,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,000.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,325,000.00 | 21,324,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,325,000.00 | 21,324,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 272,240,400.00 | 264,109,008.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 272,240,400.00 | 264,109,008.40 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 69,962,400.00 | 62,347,008.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 202,278,000.00 | 201,762,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,941,561,400.00 | 4,956,422,244.10 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 291,634,200.00 | 291,634,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 291,634,200.00 | 291,634,200.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,317,320,700.00 | 4,330,507,428.10 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,317,320,700.00 | 4,330,507,428.10 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 332,606,500.00 | 334,280,616.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,406,000.00 | 61,992,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 279,998,100.00 | 272,288,416.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,202,400.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 2,202,373.74 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 361,100,574.71 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92,870.6 мянган төгрөгийн алдаа[1] зөрчил илэрч, санхүүгийн тайланд 43,373.7 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- ЭМГ-с авсан санхүүжилтийн орлогыг дутуу бүртгэсэнтэй холбоотой харилцахын үлдэгдэл болон тайлант оны үр дүн зөрүүтэй илэрхийлсэн 13,212.4 мянган төгрөг
- ЭМЯ-с хөрөнгө оруулалтаар ирсэн 26,525.0 мянган төгрөгийн үнэ бүхий Тоёота пробокс авто машиныг данс бүртгэлд тусгаагүй
- Үнэ төлбөргүй ЭМГ-с ирүүлсэн 3,636.3 мянган төгрөгийг худалдаж авснаар бүртгэж өглөг үүсгэснийг тус тус залруулав.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ‘’аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх’’ заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 49,496.9 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил[2] илэрсэнд 2,106.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 22,728.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 24,662.8 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 52,210.4 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1. **Төлбөрийн акт**

**3.1.1** Тайлант онд зарцуулсан эмийг түүвэрлэн анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 1755 ширхэг 2,106.0 мянган төгрөгийн цагийн тариаг илүү зарлагадсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**3.2 Албан шаардлага**

**3.2.1** Тайлант онд Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 16,866.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" , Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

**3.2.2** Тайлант онд зарцуулсан шатахууныг анхан шатны баримттай тулган шалгахад замын тооцооны хуудасгүй, бараа материалын тайланг сар бүр гаргаж тооцоо бодоогүй, шатахууныг бараа материалын тайлангаас илүү дүнгээр зарлагадсан асуудалтай холбоотой 5862.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**3.3.1. Эдийн засгийн ангилалт, төсвийн төлөвлөлттэй холбоотой**

***Илрүүлэлт:*** Тайлант онд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд батлагдсан 2,227.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр хоол хүнсний зардалд, орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 8000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “ Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “ Зардлын ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж***: Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэж, зарцуулалтыг үнэн зөв гаргах,

**3.3.2 Бараа материалын эм, эмнэлгийн хэрэгслийн данстай холбоотой**

***Илрүүлэлт:*** Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэснээс үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, үүний дотор 14,435.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг бөөн дүнгээр бүртгэж он дамжсан үлдэгдэл гаргасан нь эмийн үлдэгдэлд нөлөөлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Эм боох материалын тооллого хийж, тусгай зориулалтын материалыг данс хооронд шилжүүлэх, хугацаа дууссан эм, боох материалын болон бөөн дүнгээр бүртгэсэн үлдэгдлийн талаар шийдвэр гаргах

**3.3.3. Бараа материалын эм, эмнэлгийн хэрэгслийн данстай холбоотой**

***Илрүүлэлт:*** Тайлант онд олгосон цалин хөлс, нэмэгдлийг анхан шатны баримттай тулган шалгахад илүү цагийн хөлсийг "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-р баталгаажуулан олгоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ..... гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Ажилтнуудад илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгохдоо Засгийн газрын тогтоолын дагуу олгох хуудсаар баталгаажуулан олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### *4.1 **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*** *\/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭМГ-с авсан санхүүжилтийн орлогыг дутуу бүртгэсэнтэй холбоотой харилцахын үлдэгдэл болон тайлант оны үр дүн зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 13,212.4 | | | 1 | 13,212.4 | 1 | 13,212.4 |
| ЭМЯ-с хөрөнгө оруулалтаар ирсэн Тоёота пробокс авто машиныг данс бүртгэлд тусгаагүй | 1 | 26,525.0 | 1 | 26,525.0 | | | 1 | 26,525.0 |
| Үнэ төлбөргүй ЭМГ-с ирүүлсэн 3,636.3 мянган төгрөгийг худалдаж авснаар бүртгэж өглөг үүсгэсэн | 1 | 3,636.3 | | | 1 | 3.636.3 | 1 | 3,636.3 |
| **Нийт дүн** | **3** | **43,373.7** | **1** | **26,525.0** | **2** | **13,212.4** | **3** | **43,373.7** |

### *4.2 **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*** *\/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 1755 ширхэг цагийн тариаг илүү зарлагадсан | 1 | 2,106.0 | 1 | 2,106.0 | | | | |
| Тайлант онд Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй | 1 | 16,866.0 | | | 1 | 16,866.0 | | |
| Тайлант онд зарцуулсан шатахууныг анхан шатны баримттай тулган шалгахад замын тооцооны хуудасгүй, бараа материалын тайланг сар бүр гаргаж тооцоо бодоогүй, шатахууныг бараа материалын тайлангаас илүү дүнгээр зарлагадсан | 1 | 5,862.1 | | | 1 | 5,862.1 | | |
| Тайлант онд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд батлагдсан 2,227.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр хоол хүнсний зардалд зарцуулсан, Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 8000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн | 1 | 10,227.5 | | | | | 1 | 10,227.5 |
| Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнээс үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, үүний дотор 14,435.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг бөөн дүнгээр бүртгэж он дамжсан үлдэгдэл гаргасан нь эмийн үлдэгдэлд нөлөөлж байна | 1 | 14,435.3 | | | | | 1 | 14,435.3 |
| Тайлант онд олгосон цалин хөлс, нэмэгдлийг анхан шатны баримттай тулган шалгахад илүү цагийн хөлсийг "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-р баталгаажуулан олгоогүй | 1 | 0 | | | | | 1 | - |
| **Дүн** | **6** | **49,496.9** | **1** | **2,106.0** | **2** | **22,728.1** | **3** | **24,662.8** |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |